



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/160

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Монгол Улсын Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дахь хэсгийн 2.1.4, 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тив, Дэлхий, Монгол Улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилт гаргасан тамирчид, дасгалжуулагчдад шагнал гардуулах “Мөнгөн арслан” ёслолын арга хэмжээ, аймгийн Улаан загалмайн хорооны хүүхэд залуучуудын хөдөлгөөний “SANTA CHALLENGE” аян, Хурдан үйлчилгээний төвд хийгдсэн вакум тасалгаа, “Эх оронч залуу” арга хэмжээ, аймгийн Засаг даргын нэрэмжит шагналын нөөц бүрдүүлэх, албан хэрэгцээний дотоод зардалд 9,204,550 төгрөгийг баталж зарцуулсугай.

2. Тус арга хэмжээнүүдэд зарцуулагдах 9,204,550 (есөн сая хоёр зуун дөрвөн мянга таван зуун тавь) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Сандагсүрэн)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Э.Уртнасан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



М.АМАРСАНАА

8400001 2679  
Zah A/160 Ba

Засаг даргын 2024 оны  
12 дугаар сарын 19-ний өдрийн  
А/160 дугаар захирамжийн хавсралт



### ЗАРДЛЫН ЗАДАРГАА

Д/д	Арга хэмжээ	Зориулалт	Нийт үнэ
1.	Тив, Дэлхий, Монгол Улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилт гаргасан тамирчид, дасгалжуулагчдад шагнал гардуулах "Мөнгөн арслан" ёслолын арга хэмжээний зардал	Гарын бэлэг, ус ундаа	577,500
2.	Улаан загалмайн хорооны хүүхэд залуучуудын хөдөлгөөний "SANTA CHALLENGE" аяны бэлгийн зардал	Санта бэлэг	441,000
3.	Хурдан үйлчилгээний төвд хийгдсэн вакум тасалгаа хийх зардал	Албан хэрэгцээнд	4,003,550
4.	"Эх оронч залуу" арга хэмжээний зардал	Гарын бэлэг, ус ундаа	151,750
5.	Аймгийн Засаг даргын нэрэмжит шагналын нөөц бүрдүүлэх зардал	Хавтас 200ш	3,000,000
6.	Албан хэрэгцээний дотоод зардал	-----	1,030,750
	Нийт		9,204,550

-oOo-